

БАТЛАВ. ЗАСАГ ДАРГА:  Х.БАТТУЛГА

ЗАХИАЛАГЧ :ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТӨСЛИЙН НЭР: "ЦАГААН ДЭВ"ИЙН РАШААНЫГ ХАШИЖ  
ТОХИЖУУЛАХ "АЖЛЫН ТЕНДЕРИЙН  
БИЧИГ БАРИМТ

ГЭРЭЭНИЙ ДУГААР- БХНСЗ/2019/03

2019 он

2019.05.20

Батлав: Дорнод аймгийн Баян-Уул сумын  
Засаг дарга... Х.Баттулга



**БАЯН-УУЛ СУМЫН ӨВӨР-ЭРЭЭН БАГИЙН НУТАГТ БУЙ  
"ЦАГААН ДЭВИЙН БУЛАГ"-ИЙН ХЭСГИЙГ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ  
АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

1. Зураг төсөв зохиох үндэслэл: Баян-Уул сум ЗДТГазар. Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн зардлаар.

2. Захиалагч: Баян-Уул сум. ЗДТГазар

3. Барилга байгууламжийн нэр, байршил: Баян-Уул сум 6-р багт. "ЦАГААН ДЭВИЙН БУЛАГ, РАШААН"-ы хэсгийг хамгаалах, тохижуулах

4. Архитектур төлөвлөлтийн шаардлага, хүчин чадал: Орон нутгийн чанартай рашааныг ундруулдаг уг булаг /элэг, цес, хоол боловсруулах эрхтэнд сайн гэгддэг/ нь ОХУ руу гардаг босоо тэнхлэгт засмал замын дагуу сумаас 31км-т байрладаг, аялагч, иргэдийн байнга очдог газар бөгөөд өөр хот, аймаг сумаас иргэд байнга очин уг рашааныг залдаг болоод байгаа нь хамгаалах үндэслэл нь болж ундаргыг нь тасалдуулахгүй, ойр орчмын экологийн тэнцвэр алдагдахаас сэргийлж, аялал жуулчлал хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1. Хамгаалах ажлын үндсэн даалгавар:

1. Рашаан авдаг хэсгийн хашаажуулсан дотор байгалийн чулуугаар усан сан үүсгэх:

-Уг усан сан нь рашааныг хадгалах зориулалттай биш бөгөөд рашаан дундуур нь урсан гарах зориулалттай байна. Усан санг хийхдээ байгалийн хавтгай чулуугаар ямар нэгэн барьцалдуулагч материал оруулалгүйгээр үелэн өрж рашааныг утган авах зориулалттайгаар засна.  
/1.5x1.5 метр/

-Рашаан авах зориулалттайгаар хашсан хашааны будгийг сэргээх бөгөөд квадрат төмрөн шон болон хайс болгоны оройд борооны уснаас хамгаалсан гоёлын хамгаалалт хийж өгөх.

2. Автомашины зогсоолоос булаг хүртэл 150 метр замыг 1 метрийн өргөнөөр байгалийн ердийн хавтгай чулууг газарт шигтгэн дэвсэн байсныг өөрчлөн явган замын хавтанг бетон зуурмагаар бэхжүүлэн зориулалтын хашлага хийн тогтоох.

3. Автомашины зогсоолын хязгаарлах бүсийг модоор шийдсэн байсныг төмөр трубагаар /хөндлийг 76 диаметртэй, хөлийг 100 диаметртэй хар төмөр труба/ сольж нэмж нийт 18 метр болгон цагаан, цэнхэр будгаар алаглуулан будах.

4. Амрах зуны сүүдрэвчний сандал, ширээ, дээврийг янзлах /хөл хийх болон будах, ханзарсан хэсгийг нөхөх/

5. Хогийн савыг 1.5м<sup>3</sup>-с багагүйгээр шинээр төмрөөр хийж будах. Нугастай тагтай байх

6. Тэмдэг, тэмдэглэгээ: Рашааны эрдэс бодис болон туст чанарын талаарх мэдээллийг агуулсан самбарыг рашаан авдаг хэсгийн хажууд байрлуулах. /1.0х1.5 м/

7. Рашааны 5 ундаргыг тэмдэглэсэн жижиг шонт самбар босгож байрлуулах.

2. Гүйцэтгэл хийх хугацаа: 2019 онд

3. Онцгой нөхцөл: Үгүй

Боловсруулсан: Баян-Уул сумын

Засаг даргын орлогч *Шамс-Увс* Ш.Төмөр-Ивээлт/

## Нэг.ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.06.03

Тендер шалгаруулалтын дугаар:БОХНСЗ/2019/03

*Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар* эрх бүхий тендерт оролцогчдоос **“Цагаан дэв”-ийн рашааныг хашиж тохижуулах**” ажлын битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны тодорхойлолт болон бусад холбогдох материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь *цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.*

Тендерийн бичиг баримтын үнийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт орлогын дансны 100071155402 тоот дансанд иж бүрдлээр нь **50,000** төгрөгөөр худалдан авах бөгөөд тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:*2018 оны борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.*

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: *Санал болгож буй үнийн дүнгийн 10 хувиас багагүй байна.*

Тендерийг *2019 оны 06 дугаар сарын 17 -ны өдрийн 14 цаг 30 минутаас* өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг *2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 15 цаг 00 минутаас* нээнэ.

Орон нутгийн давуу эрх тооцохгүй бөгөөд гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Дорнод аймгийн Баян-Уул сум 4 дүгээр баг  
ЗДТГазар Утас 99573342*

## Нэг.ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2,1,Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2,2Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3,1 Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэнд заасны дагуу тендерт оролцогчид тендерийн бичиг баримтыг бүрдүүлнэ.
- 4. Тогтмол үнэ**

4,1 Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5,2Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5,1 Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6,1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7,1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7,1,1Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Àóðàà. ÒÁŌí ÈÈÈÉí Ōí Āî ÐŌí ÉÉí Èò

1. **Àóðààí û òî äî ðŌí ééí èò:** ÇĀŌĀçàð í ü Баян-Уул сумын 6-р багт харьяалагдах “Цагаан дэв”-ийн рашааныг хашиж тохижуулах ажил ажил, хийнэ.

Í ýð	Ōí äî ðŌí ééí èò	Ōí ø èðŏýā	ŌŌ <sup>a</sup> Ō-ā çàāñáí ááðààā òçðāýŏ ýŏñèéí öýā	Í ééèççèýŏ ŏàí æéí ýŏí èé ŏóāòàà	Í ééèççèýŏ ýŏñèéí ŏóāòàà	Í ééèççèýā ±ééí ñáí àè áí èā ñí í ŏóāòàà
<b>Ōáŏí èèèéí òî äî ðŌí ééí èò-01</b>						
Цагаан дэвийн рашааг хашиж тохижуулах ажил	Тодорхойлолтонд заагдсан ажлын даалгаварын дагуу төсөв боловсруулна.		ø	Áàýí -Ōóè ñŏí	2019.06.25	2019.07.30

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаархи дор дурьдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа /ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой, Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 3.1	<ul style="list-style-type: none"> <li>• Үнийн санал</li> <li>• ААНэгжийн гэрчилгээний хуулбар</li> <li>• Санхүүгийн тайлан 2018 он</li> <li>• Туршлагын мэдээлэл /гэрээний хуулбар,бусад бичиг баримт</li> <li>• Харилцагч банкны байгууллагуудын өр зээлийн тодорхойлолт</li> <li>• Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>• Татварын байгууллагын тодорхойлолт</li> <li>• Шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тодорхойлолт</li> <li>• Бэлтгэж ирүүлэх бусад холбогдох материал</li> <li>• Борлуулалтын орлогын хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.</li> <li>• Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой зээлийн үнийн дүн:Санал болгож буй үнийн дүнгийн 10 хувиас багагүй байна.</li> <li>• Ижил төстэй ажлын турлага</li> </ul>
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: <b>2019 оны 06-р сарын 17-ны 14.30</b> минут Байгууллагын хаяг: <b>Баян-Уул сумын ЗДТГазар</b> 2 давхар 203 тоот өрөө , <b>2019 оны 06 дугаар сарын 17 -ны өдөр</b>
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Баян-Уул сумын ЗДТГ-ын 203 тоот</b> Давхар болон өрөөний дугаар: <b>Баян-Уул сумын ЗДТГ-ын 203 тоот өрөө</b> Огноо: <b>[2019 оны 06 дугаар сарын 17-ний өдөр]</b>  Цаг: <b>[15 цаг 00 минут]</b>
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй <b>Санхүүжилтын эх үүсвэр нийт 15,0 сая төгрөг.Үүнээс:</b> Аймгийн БОХНСЗардлын хөрөнгө оруулалтаар 15.0 сая төгрөг

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Дорнод аймгийн Баян-уул сумын**Засаг дарга **Х.Баттулга** танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо]хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо Ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг

2. **НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.



Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

- 1. Шалгах болон турших**

1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**

2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
- 3. Оюуны өмчийн эрх**

3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
- 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх**

4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (^COTERM3) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 5. Баталгаат засварын хугацаа**

5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [3] жил байна.
- 6. Гэрээнд өөрчлөлт оруулах**

6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
- 7. Төлбөр**

7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [30] хоногийн дотор шуурхай хийнэ.

8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 8. Бараа нийлүүлэх хуваарь**

9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 9. Алданги оногдуулах**

10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- 11. Маргааныг шийдвэрлэх**

- 1. Шалгах болон турших (ГЕН - 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны 2.1 нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН - 2)**
- Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН - 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup>**
- Алданги оногдуулах хувь: Нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувь байна.
- Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна.

ЗАХИАЛАГЧ

БАТЛАВ.  
НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

Нэг талаас **[захиалагчийн нэр]**(цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]**(цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]**(цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны дугаар сарын \_\_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны дугаар сарын \_\_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup>  
<sup>4</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]